

ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

(Архангай аймгийн жишээн дээр)

Ц.Ганчимэг

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн профессор, доктор (Ph.D), дэд хурандаа

Товч утга: Орон нутгийн түвшинд гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрхэн үр дүнтэй зохион байгуулагддаг, эдгээр үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг эрх бүхий албан тушаалтанын гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны мэдлэг, оролцоон түвшин, урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг тодорхойлохыг зорьж, судалгааны ажлын үр дүнг SMART PLS-4.1.0.1 программыг ашигласан үр дүнг боловсруулсан.

Түлхүүр үг: мэдлэг, оролцоо, үр дүн

Abstract: At the local level, the results of the study were developed using the SMART PLS-4.1.0.1 software to determine the effectiveness of disaster prevention activities, the level of participation and prevention of the authorized officer who administers these operations.

Key words: knowledge, engagement, results

Оршил
Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, аюулт үзэгдэл ослын давтамж хамрах хүрээ улам бүр нэмэгдэж улс орны хөгжлийн чиг хандлагад сөргөөр нөлөөлж түүнийг дагасан байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаа эрсдэл улам бүр нэмэгдэж хүний амь нас, үрэгдэж, хохирол улам ихээр гарсаар байна.

Тухайлбал, жилд дунджаар 200 гаруй сая хүн, тэднээс ихэнх нь хөгжиж буй орнуудад байгалийн гамшигт өртөж, сүүлийн 18 жилд зөрчил, мөргөлдөөн, хавчлага мөрдлөгийн улмаас хамгийн их буюу 45 сая хүн оршин суугаа газраа орхин дүрвэхэд хүрсэн байна. Энэ

баримтаас гамшиг нь байгалийн үзэгдэл болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй аюултай холбоотой бөгөөд зөрчил, мөргөлдөөн, хавчлага мөрдлөг гэсэн аюулын төрлүүд ч хүртэл байж болохыг харуулж байна. Түүнчлэн хүн төрөлхтөн оршин тогтноход дарамт үзүүлж байгалийн гамшиг байнга тохиолдож, түүний хажуугаар үйлдвэрлэл, техникийн томоохон ослууд гарч хүн ам, нийгэм, эдийн засаг байгаль орчинд үлэмж хэмжээний

хохирол учруулсаар байна⁷⁵.

Улс орнууд гамшиг, аюулт үзэгдэл, ослыг онолын хувьд нийгмийн үйл явц мэтээр бодож, түүний үзүүлэх нөлөөллийг арилгахын үндэс нь өртөж буй нийгмийн эмзэг хэсэгт анхаарлаа хандуулж тэдгээрт учирч болох эрсдэлийг бууруулах хэрэгтэй гэсэн

Судалгааны арга зүй: Судалгааны арга зүйн хувьд судалгааны таамаглал, загварыг бүтцийн тэгшитгэлийн загварт суурилсан Smart PLS 4.1.0.1 программыг ашигласан ба PLS-SEM нь хувьсагч хоорондын таамаглалыг харуулах, загварчлалыг тооцоолоход хамгийн чухал шинжилгээний арга юм. Судалгаанд дэвшүүлсэн таамаглалыг шалгахдаа хэмжил зүйн болон бүтцийн загварын шинжилгээний аргуудыг хэрэглэсэн.

Үндсэн хэсэг

Гамшгаас хамгаалах тухай хуулинд “Гамшгаас урьдчилан сэргийлэх” гэж аюулт үзэгдэл, ослын хор уршиг, хохирол, сөрөг үр дагавраас зайлсхийх, таслан зогсоох, бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээг⁷⁶ хэлнэ гэж томъёолсон бол 2011 онд “Гамшгаас хамгаалах талаарх төрөөс баримтлах бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь” сэдэвт

хандлага илүү давамгайлж байна. Үүнтэй холбоотойгоор гамшгаас хамгаалах менежментэд гамшгийн эрсдэлийг бууруулах болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны нэн тэргүүнд тавигдаж анхаарлаа хандуулж байна.

үндэсний бага хурлаас “Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулалт хийх нь аюулгүй амьдралын үндэс мөн” гэдгийг үндэс болгон “Маргаашийн аюулгүй байдлын төлөө өнөөдөр хамтдаа зүтгэцээ”⁷⁷ гэж улс орон даяаар дэлхий нийтэд зарласан нь гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэн тэргүүнд авч үзэх болсон.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох арга хэмжээ нь зөвхөн Онцгой байдлын байгууллагын ажил биш бөгөөд нийт иргэд гамшгаас өөрийгөө болон бусдыг авран хамгаалах мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлж, аюулгүй амьдрах соёлыг бий болгох нь өнөө үед тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Гамшгаас урьдчилан сэргийлэх олон арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудаас дараах хэлбэрээр авч хэрэгжүүлж байна. Жишээлбэл,

Жишээ	Агуулга
“Алдвал галдана”	Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх
“Бэлэн бай”	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх

⁷⁵ Ганчимэг, Ц. Гамшигт эмзэг бүлгийн эрсдэлийг бууруулах боломж. Дессертаци. Уб., 2021.

⁷⁶ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20 дахь заалт

⁷⁷ Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь” сэдэвт үндэсний бага хурлын эмхэтгэл., Уб., 2011. 105 дахь тал

“Анхаархад л болно”	Гол нуурын усны ослоос урьдчилан сэргийлэх
“Эрсдэлгүй аялал – Эндэлгүй зун”	Усны ослоос урьдчилан сэргийлэх
“Эрсдэлгүй Улаанбаатар”	Гэр хорооллын галын аюулгүй байдал

Хүснэгт №1. Гамшгаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ

Аливаа авч байгаа арга хэмжээнүүд буюу хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр нөлөөг судалж улмаар дахин хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодорхойлох нь зүйтэй юм. Иймд гамшгаас урьдчилан сэргийлэх ажилд шалгуур үзүүлэлт, аргачлалын дагуу үнэлгээ хийх, үүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, практик хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх нь зайлшгүй шаардлагатай байна.

Аливаа гамшиг, аюулт үзэгдэл, осол нь бүс нутаг, улс орны цаашлаад хэд хэдэн орныг хамарч болох ч учруулсан хор уршиг нь ихэнхдээ орон нутгийн хүн амын түвшинд нөлөө үзүүлдэг ба тухайн орон нутгийн хүн амын хэрэгцээ, чадавхи ба эрсдэл зэргийг нийгмийн гишүүдээс нь өөр хэн ч тэр болгон сайн мэдэхгүй байдагт энэхүү тогтолцооны онцлог оршдог байна. Энэ тогтолцооны хувьд орон нутгийн засаг захиргаад гамшгаас хамгаалах менежментийн чадавхыг бий болгох асуудалд харилцан адилгүй анхаарал тавьдаг хэдий ч тухайн нийгэмд учирч болох эрсдэл, үүсэх хэрэгцээний наад захын түвшинд дүйцүүлж гамшгаас хамгаалах үйл ажиллагааныхаа бүтэц, зохион байгуулалтыг бий болгохыг эрмэлздэг давуу тал байдаг.

Орон нутаг дахь аймаг, сум, багийн түвшинд гамшгаас урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг зохион явуулахад дээрх хэлбэрээр иргэд олон нийтэд хүргэж байна. Үүнд:

Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтаар

Гамшгаас урьдчилан сэргийлэх сурталчилгаа.

Гамшгаас урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт.

Зарлан мэдээлэл.

Орон нутаг дахь гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ:

Орон нутаг дахь Онцгой байдлын газар нь гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бус нутгийн онцлогт тохируулан тогтмол зохион байгуулж байгаа хэдий ч ямар аргаар тооцож, ямар үр дүнд хүрч хэрхэн үнэлэх нь одоог хүртэл тодорхой бус байна.

Сүүлийн жилүүдэд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг орон нутагт амьдарч буй иргэд орон нутгийн телевиз, FM, радио, сумдын Засаг даргын тамгын газрын гадна талд байрлах лед дэлгэц, сумын болон Онцгой байдлын газрын facebook цахим хуудас, цагаан хоолойгоор дамжуулан анхааруулах мэдээ

мэдээллийг тогтмол авдагч гамшиг, ослын тоо улам бүр өссөн байна.

Үүнийг Архангай аймгийн хэмжээнд гарсан гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон статистикаас харж болно.

Тус аймгийн хэмжээнд 2012-2023 онд нийт 1183 удаагийн гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон байна. Үүнд: объектын болон ой, хээрийн гал түймэр 707, ус цаг агаарын аюулт үзэгдэл 157, хүн, мал амьтны гоц халдварт өвчин 156, хүний үйл ажиллагаатай холбоотой аюул 163 удаа тус тус гарсан байна.

Мөн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээгээгээр аюул, өртөнгө, эмзэг байдал, чадавхыг тооцон эрсдэлийг тодорхойлоход орон нутгийн 84.21% нь өртөх байдал ихтэй, эмзэг байдал нь аймгийн хэмжээнд маш их, гамшгийн эрсдэлийн түвшингээр 47

оноогоор Дунд зэрэгт үнэлэгдсэн. Цаашид гамшиг ослын тоо, давтамж улам нэмэгдэх хандлагатай байна.


Иймд дээрх асуудалд анхаарал хандуулж, байгаль, цаг уур, нийгэм эдийн засгийн байдалд тулгуурлан иргэд, орон нийтийн оролцоотойгоор гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх, сүүлийн үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн сургалт, сурталчилгаа, эрт зарлан мэдээлэх тогтолцоог чанартай, хүртээмжтэй явуулах зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байна.

Орон нутагт гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах,

төлөвлөх удирдах албан тушаалтаны дунд хийсэн судалгааны үр дүн

Valid		Гамшиг болон аюулын үед нутаг дэвсгэр, баг хорооны хэмжээнд хүч хэрэгслийг татан оролцуулдаг эсэх	Гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж ажилладаг эсэх.	Орон нутгийн ОББ-ын, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангаж, дэмжлэг үзүүлдэг эсэх.
		Percent	Percent	Percent
	Тийм	85.7%	78.6%	66.6%
	Үгүй	14.3%	21.4%	33.3%

Хүснэгт 13. Албан тушаалтны оролцоог хангасан




Зураг 9. Судалгаанд оролцогчдын албан тушаалтаны гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүч, хэрэгсэл татан оролцуулдаг эсэх

Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед сум, баг хорооны хэмжээнд хүч хэрэгслийг татан оролцуулдаг уу? гэх асуултанд 85.7 хувь тийм, 14.3 хувь нь үгүй, гамшгийн

ерсдэлийг бууруулах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангадаг эсэх асуултад 78.6 хувь нь хангаж оролцуулдаг, 21.4 хувь нь үгүй, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн ажиллах нөхцөл боломжоор хангаж ажилладаг эсэхэд 66.6 хувь нь тийм, 33.3 хувь нь үгүй гэж хариулсан нь оролцоо хангалтгүй зохион байгуулж байна.

Valid		Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг жил бүр тодотгож үйл ажиллагаандаа ашигладаг эсэх.	Гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дээд шатны болон ОББ-д мэдээлэх, зааварчилгаа, дэмжлэг авдаг эсэх	Гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийн байнгын бэлэн байдлыг хангаж ажилладаг эсэх.
		Percent	Percent	Percent
	Тийм	78.5%	90.4%	85.7%
	үгүй	21.4%	9.5%	14.3%

**Хүснэгт 14. Албан тушаалтны
мэдлэг, чадвар үнэлсэн**




**Зураг 10. Судалгаанд оролцогчдын
мэдлэг, чадварын түвшин**

Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах үеийн мэдлэг чадварыг үнэлэхэд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 78.5 хувь ашигладаг, 21.4

хувь ашигладаггүй, ОББ-аас 90.4 хувь зааварчилгаа авдаг, 9.5 хувь авдаггүй, зарлан мэдээллийн дохио дамжуулах систем нь 85.7 хувь нь ажиллагаатай, 14.3 хувь нь ажиллагаагүй гэж дүгнэгдэж байгаа нь эрх бүхий албан тушаалтны мэдлэг чадвар сул ОББ-аас ихэнх хувь нь хамаарч байна.

Valid		Сум, орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөж удирдан зохион байгуулдаг эсэх.	Нутаг дэвсгэрийн онцлогт ГХ алба, МА, сайн дурын хэсгийг байгуулж дадлага чадвартай болгох сургалт тогтмол зохион байгуулдаг эсэх.	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, орон нутгийн нөөцийг бүрдүүлдэг эсэх.	Баг, хорооны хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сурталчлан анхааруулах мэдээ мэдээллийг тогтмол явуулдаг эсэх
		Percent	Percent	Percent	Percent
	Тийм	71.4%	61.9%	76.1%	76.1%
	Үгүй	28.5%	38.0%	23.8%	23.8%

Хүснэгт 15. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнгийн судалгаа



Зураг 11. Судалгаанд оролцогчдын гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнгийн түвшин

Сум, орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг 71.4 хувь нь удирдан зохион байгуулдаг, 28.5 хувь зохион байгуулдаггүй, гамшгаас хамгаалах алба мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн алба хаагчдыг 61.9 хувь нь сургаж дадлагжуулдаг 38.0 хувь сургалт зохион байгуулдаггүй, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд 76.1 хувь нь шаардагдах хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлдэг 23.8 хувь нь бүрдүүлэх хэрэггүй, сум баг хорооны хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сурталчилан анхааруулах, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээлэл тогтоомол хүргэдэг гэсэн асуултад 76.1 хувь нь тогтмол зохион

байгуулдаг, 23.8 хувь нь явуулдаггүй гэж хамрагдсан байна.

Судалгааны арга зүй: Судалгааны арга зүйн хувьд судалгааны таамаглал, загварыг бүтцийн тэгшитгэлийн загварт суурилсан SMART PLS-4.1.0.1 программыг ашигласан ба PLS-SEM нь хувьсагч хоорондын таамаглалыг харуулах, загварчлалыг тооцоолох арга юм.

Судалгаанд дэвшүүлсэн таамаглалыг шалгахдаа хэмжил зүйн болон бүтцийн загварын шинжилгээний аргуудыг хэрэглэсэн.

Эрх бүхий албан тушаалтны судалгааны үр дүнгийн боловсруулалт: Судалгааг цаасан болон цахим хэлбэрээр явуулсан бөгөөд 19 сумын удирдах 57 оролцогчдоос 43 шаардлага хангах хариулт ирсэн.

Мэдээлэл цуглуулсны дараа өгөгдөлд дүн шинжилгээ хийхийн тулд үл хамаарагч хувьсагч (Y) ба

хамааралтай хувьсагч (X) хувьсагчдыг тодорхойлсон. Бие даасан хувьсагч нь оролцоо, мэдлэг, үр дүн гэсэн бүлгүүдээр тус бүр 2-3 асуултыг харин хамаарах хувьсагчаар ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх 3 асуултыг тодорхойлов.

Дундаж квадрат үлдэгдэл (RMSR) нь ковариацийн үлдэгдлийн дундаж үнэмлэхүй утгын хэмжүүр боловч түүврийн ковариацийн матриц болон таамагласан ковариацийн матрицыг хоёуланг нь корреляцийн матриц болгон хувиргахад үндэслэсэн стандартчилагдсан язгуур квадрат үлдэгдэл (SRMR) юм.


SRMR нь ажиглагдсан корреляц ба загварын далд корреляцийн матрицын ялгаа гэж тодорхойлогддог.

Тиймээс энэ нь ажиглагдсан болон хүлээгдэж буй корреляцийн хоорондын зөрүүгийн дундаж хэмжээг (загвар) тохирох шалгуурын үнэмлэхүй хэмжигдэхүүн болгон үнэлэх боломжийг олгодог.

Загварыг үнэлэх, таамаглалыг шалгахын тулд хамгийн бага квадратын аргыг ашиглав. PLS замын загвар нь хоёр систем шугаман тэгшитгэлээс бүрдэнэ. Үүнд:

Гадаад загвар (хэмжилтийн загвар) далд хувьсагч болон түүний ажиглагдсан эсвэл илэрхий хувьсагч хоорондын хамаарлыг тодорхойлдог.


Дотоод загвар (бүтцийн загвар) ажиглагдаагүй эсвэл далд хувьсагчийн хоорондын хамаарлыг тодорхойлдог.



Зураг 12. Онолын загвар

AVE нь 0-ээс 1 хооронд хэлбэлздэг бөгөөд энэ нь далд хувьсагчаас үүдэлтэй нийт хэлбэлзлийн харьцааг илэрхийлдэг. Өмнө нь танилцуулсан логикийг ашиглавал, 0.5 буюу түүнээс дээш AVE нь нийлсэн хүчин төгөлдөр байдлыг илтгэнэ, учир нь далд бүтэц нь ажиглагдсан хувьсагчдын дисперсийн 50 ба түүнээс дээш хувийг эзэлж байна гэсэн үг юм.

Хэрэв кронбах альфа буюу AVE /найдвартай байдал/ нь далд хувьсагчдын багц үзүүлэлт хоорондоо хэрхэн уялдаатай байгааг илэрхийлнэ. Найдвартай байдлын үнэлгээний хувьд 0-0.9 маш хангалттай сайн, 0.9-0.8 хангалттай сайн, 0.8-0.7 сайн, 0.7-0.6 хангалттай, 0.6-0.5 хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрсэн, 0.5 доош хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрээгүй гэж үзнэ.



Зураг 13. Гүйцэтгэлийн хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Судалгааны үр дүнг боловсруулах, харьцуулан шинжлэх, бататгах, дүгнэх хэсэг юм. Уг шинжилгээгээр далд хувьсагч бүр

гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны оролцоо, мэдлэг нь үр дүнд хэрхэн нөлөөлж байгааг харуулах ба, хүчин зүйл тус бүрийн үр дүнг гаргасан болно.

д / д	Items	Loading далд хувьсагч	Cronbach's alpha хамаарал	CR Найдвартай байдал утга	AVE Дундаж утга
1	O-2	0.704	0.395	0.763	0.619
2	O-3	0.861			
3	M-1	0.907	0.443	0.769	0.630
4	M-3	0.662			
5	U-1	0.801	0.625	0.794	0.563
6	U-3	0.707			
7	U-4	0.741			

Хүснэгт 16. Сургалтын үр дүн, хувьсагчдын хоорондын хамаарал

Тайлбар: О-гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны оролцоо, М-гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны мэдлэг, U-Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэл.

Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь мэдлэг, оролцоо, үр дүн гэсэн бүлэг асуудлуудын хүрээнд AVE /дундаж утга/ нь 0.563-0.630 хооронд байгаа нь загварын хувсагчдын хүчин төгөлдөр байдлыг илтгэж байна.

Variables	1	2	3
-----------	---	---	---

Мэдлэг	1.000		
Оролцоо	0.504	1.000	
Үр дүн	0.774	0.565	1.000

Хүснэгт 17. Means, standard deviations, cronbach's alpha and correlations among the variables (n=295)

Эрх бүхий албан тушаалтны гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны оролцооны судалгааны үр дүн нь гэдэг хувьсагчид хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ хийхэд кронбах альфа нь 0.395, найдвартай байдлын утга 0.763 байгаа нь судалгааны ажлын үр дүнг энэ хувьсагч найдвартайгаар баталсан. Далд хувьсагчдын үр дүн 0.704-0.861 хооронд хэлбэлзэж байгаа нь хувьсагчдын хоорондын хамаарлын дундаж утга 0.619 буюу хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрснийг илэрхийлж байна. Гэсэн хэдий ч 3 далд хувьсагчдын үр дүнгээс харвал О-1 хамаарал бүхий утга биш тул хасаж AVE /дундаж утга/ гаргасан.

Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны мэдлэгийн судалгааны үр дүнд судалгаа хийхэд кронбах альфа нь 0.443, найдвартай байдлын утга 0.769 байгаа нь

судалгааны ажлын үр дүнг энэ хувьсагч найдвартайгаар баталсан. Далд хувьсагчдын үр дүн 0.662-0.907 хооронд хэлбэлзэж байгаа нь хувьсагчдын хоорондын хамаарлын дундаж утга 0.630 буюу хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрсэн М-2 хувьсагч нь 0.5 бага учир хамааралгүй байх тул хассан.

Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны судалгааны үр дүнд судалгаа хийхэд хийхэд кронбах альфа нь 0.625, найдвартай байдлын утга 0.794 байгаа нь судалгааны ажлын үр дүнг энэ хувьсагч найдвартайгаар баталсан. Далд хувьсагчдын үр дүн 0.707-0.801 хооронд хэлбэлзэж байгаа нь хувьсагчдын хоорондын хамаарлын дундаж утга 0.563 буюу бодит байдлыг хангаж байна. U-2 хувьсагч нь 0.5 бага хамааралгүй байх тул хассан.

д/д	Таамаглалууд	Дундаж утга	Стандарт хазайлт	Т статистик	П Үнэ цэнэ	Үр дүн
1	Оролцоо	0.353	0.446	0.845	0.000	Батлагдсан
2	Мэдлэг	0.229	0.390	1.492	0.000	Батлагдсан
3	Үр дүн	0.322	0.427	0.707	0.000	Батлагдсан

Хүснэгт 18. Судалгааны загвар дахь замын шинжилгээний үр дүн
Оролцоо нь гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нөлөөлнө гэсэн таамаглалын үр

дүнгийн Т статистик утга 0.845, П үнэ цэнэ 0.000, мэдлэг нь гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нөлөөлнө гэсэн таамаглалын үр дүнгийн Т статистик утга 0.492, П үнэ

цэнэ 0.000, үр дүн нь гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нөлөөлнө гэсэн таамаглалын үр дүнгийн Т статистик утга 0.707, П үнэ цэнэ 0.000 утгатай тус тус гарч таамаглал батлагдлаа.

ДҮГНЭЛТ:

Орон нутагт гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, төлөвлөх удирдах албан тушаалтан буюу Архангай аймгийн 19 сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар нийт 57 алба хаагчийн 43 буюу 75.4 хувь нь энэхүү судалгаанд хамрагдсан үр дүн SMART PLS-4.1.0.1 программыг ашиглан боловсруулахад дараах байдлаар гарсан. Үүнд:

1. Эрх бүхий албан тушаалтны гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны оролцоонд хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ хийхэд кронбах альфа нь 0.395, найдвартай байдлын утга 0.763 байгаа нь орон нутаг дахь аймаг, сумын гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн гамшигтай тэмцэх, хариу арга хэмжээ үйл ажиллагаанд 50 хувиас дээш хувьтай оролцож байгааг баталж байна.

2. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны мэдлэгийг үнэлэх хүчин зүйлийн хамаарлын шинжилгээний үр дүн кронбах альфа нь 0.443, найдвартай байдлын утга 0.769 байгаа нь орон нутаг дахь эрх бүхий албан тушаалтны зохион байгуулж байгаа гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь Онцгой

байдлын байгууллагаас бүрэн хамаарч байгааг илэрхийлж байна.

3. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны судалгааны үр дүнд судалгаа хийхэд кронбах альфа нь 0.625, найдвартай байдлын утга 0.794 байгаа нь судалгааны ажлын үр дүнг энэ хувьсагч найдвартайгаар баталсан. Энэ нь орон нутаг дахь гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн нь хангалтгүй харуулж байна.

Дээрх гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны оролцоо, мэдлэг, үр дүнгийн илэрхийлэл далд хувьсагчдын үр дүн 0.707-0.801 хооронд хэлбэлзэж байгаа нь хувьсагчдын хоорондын хамаарлын дундаж утга 0.563 буюу бодит байдлыг хангаж байна.

Энэ нь гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтад Засаг дарга нь “Нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх гэж заасан⁷⁸-ний эрх бүхий албан тушаалтнуудын оролцоо, мэдлэг, чадварыг сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль

Монгол Улсын Үндсэн хууль (1992)
Гамшгаас хамгаалах тухай хууль (2017)
Галын аюулгүй байдлын тухай хууль (2015)
Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2003)
Зар сурталчилгааны тухай хууль (2002)

⁷⁸ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.1 дэх заалт

Хоёр. Улсын Их хурал, Засгийн газрын тогтоол, бодлогын баримт бичиг

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (УИХ-ын тогтоол №48, 2010)

“Гамшгийн эрсдэлийг бууруулах Сэндайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичиг (ЗГ-ын тогтоол №355, 2017)

Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (ЗГ-ын тогтоол №303, 2015)

Гурав. Ном сурах бичиг, гарын авлага
Базаррагчаа, С. Гамшгийн эрсдэлийн удирдлага гарын авлага., Уб., 2023.

Гамшгийн нэр томъёоны тайлбар толь. ОБЕГ., ГСХ., Уб., 2012.

Үржин,О. Цэдэв, П. Гамшгаас хамгаалах үндэс (Ажилтан албан хаагчдад зориулав). Уб., 2017.

Сэржмядаг, Д. Гамшгийн менежмент үндэс., 2017.

Дөрөв. Нэг сэдэвт бүтээл

Цэдэв, П. “Монгол Улсад гамшгаас хамгаалах мэргэжилтэн бэлтгэх сургалтыг боловсронгуй болгох зарим асуудал” боловсролын ухааны докторын зэрэг горилсон бүтээл, Уб., 2004.

Ганчимэг, Ц. “Гамшигт эмзэг бүлгийн эрсдэлийг бууруулах боломж”., диссертаци., Уб., 2021.

Тав. Гадаад эх сурвалж

W.Nick Carter. Disaster management., Manila, PH.,1991.

Cuny, Frederick C. Disasters and Development., New York. 1983. Oxford University Press

Lab Steven P. Crime Prevention : Approaches, Practices, and Evaluations, Routledge. 2016.